



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМНЫ ХАРЬАА

**БАГШИЙН МЭРГЭЖИЛ
ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУТ**

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Энхтайваны өргөн чөлөө 10, Багшийн хөгжлийн ордон,
Утас, факс: (976) 7014 0069, <http://www.itpd.mn>

2018.01.05 № 1/05

танай _____-ны № _____-г

Сургалтын хуваарь мэдэгдэх
тухай

2017-2018 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуульд 10 дахь жилдээ ажиллаж буй багш нар, эхний болон 5,10,15 дахь жилдээ ажиллаж буй зарим ажилтнуудын мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын хуваарийг үүгээр хүргүүлж байна.

Мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалт нь танхимын болон онлайн сургалт гэсэн хоёр хэсэгтэй. Танхимын сургалт төвлөрсөн болон бүсчилсэн хэлбэрээр 5 өдөр, онлайн сургалт "Багшийн цахим кампус" (esurgalt.itpd.mn) систем дээр танхимын сургалтын өмнө болон дараа тус бүр 15 хоног үргэлжилнэ. Сургалтад хамрагдвал зохих багш, ажилтнуудад мэдээллийг хүргэж, бүрэн хамруулахад анхаарч, хамтран ажиллана уу.

Мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын хуваарь болон онлайнаар бүртгүүлж, бүртгэл нь баталгаажсан багш, ажилтнуудын мэдээллийг itpd.mn цахим хуудаст байршуулсан бөгөөд боловсролын газрын ***@itpd.mn цахим хаягаар мөн илгээсэн болно.

Сургалтад хамрагдах багш, ажилтнуудад дараах зүйлсийг бэлтгэж ирэхийг уламжилна уу. Үүнд:

- Танхимын өмнөх онлайн сургалтад хамрагдсан байх
- Нийтийн тээврийн тарифт зардлаар зорчсон ирэх, буцах зардлын баталгаажуулсан баримт
- Иргэний үнэмлэх, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар
- Багшлах эрхийн үнэмлэх эх хувиар
- Зөөврийн компьютер, /боломжтой бол интернет модем/
- Сургалтын цөм хөтөлбөр
- Сургалтын хугацаанд хэрэглэх хувийн зардлаа тооцоолж, бэлтгэж ирэх зэрэг

Хавсралт. Мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын хуваарь, 2. хуудастай

ЗАХИРАЛ

А.ТУЯА



2018 0017

